

I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 18




## Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 35.9 хувиар, зарлага 26.4 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны хагас жилд 1679.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 443.2 (35.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 443.2 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 411.8 (46.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн 2021 оны 6 дугаар сард нийгмийн даатгалын сангийн орлого 426.6 тэрбум төгрөг, зарлага 417.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас орлого 172.6 (68.0%) тэрбум төгрөгөөр, зарлага 135.9 (48.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар




Нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 оны эхний хагас жилд 1718.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 359.1 (26.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 75.6 (7.1%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 250.7 (7.6 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2021 оны эхний хагас жилд 12216 хүнд 27.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 1594 (15.0 %) хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 1221.6 (4.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас 2021 оны эхний хагас жилд 456.2 мянган хүн тэтгэвэр авсны 76.1 хувь нь өндөр насны тэтгэвэр авагчид, 15.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авагчид, 8.6 хувь нь бусад (тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр) тэтгэвэр авагчид байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, төрлөөр, 2021 оны эхний хагас жилд



Нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний хагас жилд 2.3 (давхардсан тоогоор) сая хүнд 1002.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 56.7 (2.5%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 364.0 (57.0%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Монгол Улсын Засгийн газраас "Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай" 93 дугаар тогтоолын дагуу 2021 оны 6 дугаар сарын байдлаар 3.4 сая иргэнд 1010.5 их наяд төгрөгийн мөнгөн дэмжлэг олгосон байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид, тэдгээрт олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд "Хүүхдийн мөнгөн тэтгэмж" авсан 0-18 хүртэлх насны хүүхдийн тоо 46.8 (4.0 %) мянгаар, олгосон тэтгэмжийн хэмжээ 344.8 тэрбум (90.9%) төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны эхний хагас жилд 57.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.1 (3.8%) мянган хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 22.3 (32.0%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 67.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 25.7 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 6.6 хувь нь ахмад настан, 0.2 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний хагас жилд 106.6 мянган хүн хамрагдсаны 54.2 хувь нь асаргааны тэтгэмжид, 45.8 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 оны эхний хагас жилд 51.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 5.9 (12.9%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 723.9 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2021 оны эхний хагас жилд олгожээ.

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдагчид, төрлөөр

Үзүүлэлт	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021 \text{ I-VI}}{2020 \text{ I-VI}}$	%
<b>Бүгд</b>	<b>1 567 580</b>	<b>2 019 495</b>	<b>2 227 220</b>	<b>2 283 945</b>	<b>102.5</b>	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	399 209	396 784	392 942	391 222	99.6	
Тэтгэвэр	55 798	54 761	55 623	57 724	103.8	
Тэтгэмж	53 784	92 177	93 528	106 648	114.0	
Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)	289 627	249 846	243 791	226 850	93.1	
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	210 478	210 995	217 556	<b>229 048</b>	105.3	
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	789 953	971 375	1 161 679	1 208 478	104.0	
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	84 520	68 149	65 189	65 310	100.2	
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2 391	2 380	2 429	76	3.1	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	16 238	10 785	11 771	6 866	58.3	
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	64 791	230 370	235 547	235 848	100.1	
Насны хишиг	-	128 308	139 739	146 703	105.0	
Цаатан иргэний тэтгэмж	-	349	368	394	107.1	

**Ойлголт, тодорхойлолт:**

**Нийгмийн даатгал** нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын сан** гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч** гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Тэтгэвэр** гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж** нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг **нийгмийн халамж** гэнэ.



**Эх үүсвэр:** Нийгмийн даатгалын ерөнхий газар  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

**Мэдээлэл авах линк:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 8 дугаар сарын 17

Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга  
А.Амарбал  
Утас: (976-51)-264805

Хүн ам, нийгмийн статистикийн газрын  
статистикч Э.Ариунчимэг  
Утас: (976-51)-263966

